

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 16-ны өдөр

№ 21/42

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын тооллогын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан КАПИТРОН банкнаас дараахь нөхцөлийн дагуу гэрээ байгуулж, зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.

Зээлийн хэмжээ	1 (нэг) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Шугаман зээл
Зээлийн хугацаа	24 сар /2 жил/
Зээлийн хүү, шимтгэл	14.4% /жилийн/
Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд тооцох хүү	3% /жилийн/
Эргэн төлөх нөхцөл	Зээлийн хүүгийн төлбөр сар бүр, үндсэн төлбөр банктай тохирсон нөхцөлийн дагуу
Барьцаа хөрөнгө	Зээлийн багц

2. Зээл авах асуудлаар КАПИТРОН банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
3. КАПИТРОН банктай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн удирдах зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР